**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/17 Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 08 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Үндэсний үйлдвэрийн хүүхдийн автобус /Ховд, Булган, Баянсудал баг/” ажлын гүйцэтгэгч “Монгол машин индустриал” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Ганданповрон – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Ганзориг – Булган сумын Засаг даргын орлогч

А.Жамьянсүрэн -Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч

Б.Түмэнжаргал –Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Д.Чинзориг – Ховд аймгийн Авто тээврийн төвийн хяналтын улсын байцаагч

М..Гэрэлчулуун – “Монгол машин индустриал” ХХК-ний инженер

Zax A/17 Ch

02 00077

Нарийн бичгийн
дарга: Л.Батгэрэл – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. “Үндэсний үйлдвэрийн хүүхдийн автобус /Ховд, Булган, Баянсудал баг/” ажлын гүйцэтгэгч “Монгол машин индустриал” ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН